

## “Солонгос хэл, соёлын талаар өгүүлэх нь” лекц боллоо

2021-04-26

2021 оны 4-р сарын 13-нд ГХС-ийн Ази судлалын тэнхимээс БНСУ-ын Намсөүл их сургуулийн багш, доктор С.Отгонбаярыг урьж, Техник технологийн орчуулгын солонгос хэлний 3, 4-р ангийн оюутнуудад “Солонгос хэл, соёлын талаар өгүүлэх нь” сэдвээр лекц уншууллаа. С.Отгонбаяр нь БНСУ-ын Кёнги их сургуульд магистрын, Сөүлийн үндэсний их сургуульд боловсрол судлалын докторын зэрэг тус тус хамгаалсан ба 2016 оноос Намсөүлийн их сургуульд багшилж байна.

С.Отгонбаяр багшийн лекц 2 хэсгээс бүрдсэн бөгөөд эхний хэсэгтээ Солонгосын орчин үеийн түүх, тэр дундаа хоёр Солонгосын хуваагдал, Солонгосын хойгийн асуудлын тухай дэлгэрэнгүй ярьж өгсөн нь сонирхолтой байлаа.

Хоёр дахь хэсэгт орчуулга хэрхэн хийх талаар өөрт тохиолдсон жишээн дээр тулгуурлан, туршлагаасаа ярьсан нь оюутнуудын сонирхлыг татлаа. С.Отгонбаяр багш Монгол улсын болон хоёр улсын төр засгийн тэргүүдийн томоохон уулзалт, хурлын орчуулга, мөн Солонгос дахь монгол иргэдийн шүүх хурлын орчуулга хийж байсан юм. Тэрээр мэргэжлийн орчуулга хийхэд анхаарах зүйлс, орчуулагч хүний баримтлах зарчим зэргийг яриандаа онцлон дурдаж байв. Нэн ялангуяа солонгос, япон, хятад хэлний төстэй тал нь дүрс үсэг бөгөөд сайн орчуулга хийхэд ханз үсгийг зайлшгүй сурах ёстой гэснээр лекцээ өндөрлөсөн юм.




## “Солонгост хэрхэн суралцах вэ?” цуврал уулзалт

2021-04-26

Улс орон даяар цар тахалтай тэмцэж буй үед АСТ-ийн солонгос хэлний багаас оюутны сурах үйл ажиллагааг дэмжих, улам эрчимжүүлэх зорилгоор олон сайхан ажлыг зохион байгуулж байгаагийн нэг нь “Солонгост хэрхэн суралцах вэ” цуврал онлайн уулзалт юм. Үүнд:

1. 2021 оны 1 сарын 28-нд МХТС, MeTC-ийн БНСУ-ын Сүн Чён Хяны их сургуультай хамтран хэрэгжүүлж буй 2+2 хөтөлбөрийн оюутнууд 36 цагийн солонгос хэлний хичээл судалж, солонгос хэлний түвшин тогтоох шалгалт /ТОPIC/-ын 3-р түвшинд тэнцсэн тохиолдолд БНСУ-д суралцах эрхтэй болдог. Тэнхимийн солонгос хэлний багш нар тус хөтөлбөрөөр суралцаж байгаа 2-р курсийн оюутнуудад солонгос хэлний шалгалтад хэрхэн бэлтгэх талаар зөвлөгөө өглөө. Энэ уулзалтад БНСУ-ын Сүн Чён Хяны их сургуульд сурч байгаа оюутан Б.Идэрболд /MeTC/, Б.Дуулга /МХТС/ нарыг урьж, солонгос хэл хэрхэн сурсан, шалгалтад бэлдсэн туршлага болон Сүн Чён Хяны их сургуулийн хэлний бэлтгэл, үндсэн ангийн сургалтын талаар дэлгэрэнгүй яриулсан нь оюутнуудын сонирхлыг их татлаа.
2. 2021 оны 2 сарын 24-нд ГХС-ийн солонгос хэлний ангийн оюутнуудад БНСУ-ын ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэн, Сөүлийн үндэсний их сургуульд магистр хамгаалж, одоо докторантурт сурч байгаа Д.Болорцэцэгийг урьж тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах талаар уулзалт яриа зохион байгууллаа.
3. Уулзалтын дараагийн зочин нь манай 2009 оны төгсөгч Ц.Очсүрэн байлаа. Тэрээр БНСУ-ын Сүншил их сургуульд магистрын зэрэг хамгаалсан. Сөүлийн үндэсний их сургуулийн эмнэлэгт орчуулагчаар ажиллаж байгаад, одоо Олон соёлт гэр бүлийн төвд хос хэлний багш, коучаар ажиллаж байгаа. Тэрээр Солонгосын их, дээд сургуульд суралцахад анхаарах зүйл, хэл соёлын онцлог, багш оюутны харилцаа болон сургуулиа төгсөөд ажилд орох талаар зөвлөгөө өгсөн нь оюутнуудад сонирхолтой байлаа.



## Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхим онлайн лекц зохион байгууллаа

2020-10-31

Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхим нь “Техник технологийн орчуулга” мэргэжлийн ангийн оюутнуудын хэлний мэдлэгийг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор гадаадын их, дээд сургуулийн багш нарыг урьж онлайн цуврал лекц уншуулж байгаа юм.

Энэ удаагийн зочноор Азербайжаны Хэлний их сургуулийн /Университет языков/ Солонгос хэлний орчуулагчийн тэнхимийн багш, Сөүлийн үндэсний их сургуулийн докторант Нара Маликова уригдан оролцлоо. Онлайн лекцэд Солонгос хэлний багш нар болон “Техник технологийн орчуулга” мэргэжлийн 3, 4-р курсийн оюутнууд оролцсон.

Нара Маликова Азербайжаны солонгос хэлний сургалтын талаар товч танилцуулж, орчуулга хэрхэн хийх, орчуулга хийхэд тулгардаг бэрхшээл, анхаарах зүйлсийн талаар сонирхолтой лекц уншлаа. Тэрээр анх удаа өөр орны оюутнуудад хичээл зааснаа онцолж байсан бол манай оюутнуудын хувьд мөн адил солонгос мэргэжилтэн багш биш, гуравдагч орны багшаар хичээл заалгасан нь маш сонирхолтой байлаа.



# ШУТИС-ийн ГХС-ийн оюутан Монголын их, дээд сургуулиудын дунд зохиогдсон “Солонгос хэлний ярианы тэмцээн”-ээс Гран при авлаа

2019-04-18

Өнгөрөгч 4-р сарын 5-ны өдөр Монголын их, дээд сургуулиудын солонгос хэл суралцагч оюутан залуусын дунд жил бүр уламжлал болгон зохиогддог солонгос хэлний ярианы тэмцээн 21 дэх удаагаа зохион байгуулагдлаа. БНСУ-ын ЭСЯ, КОЙКА байгууллагын ивээл дор ХУИС зохион явуулдаг уг тэмцээн нь 2, 3-р курсын оюутнуудын дунд зохиогддог байсан бол энэ жилээс эхлэн их, дээд сургууль бүрээс 1~3 курсийн зөвхөн нэг оролцогч орох боломжтой болсон юм. Тэмцээн шүүгчийн асуултад хариулах, өгөгдсөн зургийг тайлбарлах, үндсэн илтгэл гэсэн 3 үе шаттай явагддаг бөгөөд энэ жилийн сэдэв "Цахим гэмт хэрэг" гэсэн харьцангуй хүнд сэдэв байв.

ШУТИС-ийн хувьд Солонгос хэлний тэнхим байгуулагдсан цагаас эхлэн энэ тэмцээнд тасралтгүй оролцож ирсэн билээ. Энэ жил ТТО мэргэжлийн 2-р курсын оюутан С.Өлзийбат амжилттай оролцон түрүүлж БНСУ-н Элчин сайдын яамны нэрэмжит “Гран при” шагнал болох Солонгос Улсад 3 сар үнэгүй суралцах эрхээр шагнууллаа. Ийнхүү бид 2014 онд 2-р байр /3-р курсын оюутан Э.Солонго/ эзэлж байсан амжилтаа ахиулж чадлаа.



## БНСУ-ын ЭСЯ-ны нэрэмжит спортын нөхөрсөг тэмцээнд

### ШУТИС-ийн оюутнууд тэргүүлээ

2019-12-07

БНСУ-ын ЭСЯ-ны ивээл дор Монголын их дээд сургуулиудын солонгос хэл суралцагч оюутнуудын дунд зохион явуулдаг спортын 6 дахь удаагийн нөхөрсөг тэмцээн 2019.11.09-ны өдөр Этүгэн их сургууль дээр болж өндөрлөлөө. Уг спортын нөхөрсөг тэмцээн эрэгтэй сагсан бөмбөг, эмэгтэй гар бөмбөг, багаараа олс таталт, багш нарын нөхөрсөг тэмцээн гэсэн 4 төрлөөр явагддаг ба ШУТИС-ийн ГХС-ийн солонгос хэлний техник технологийн орчуулагчийн анги, МХТС болон MeTC-н 2+2 хөтөлбөрийн ангийн оюутнуудын хамтарсан баг уг тэмцээнд оролцдог



уламжлалтай юм. Энэхүү тэмцээн нь оюутан залуус чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, ойртон нөхөрлөх боломж олгодог учир жилээс жилд оролцогчдын тоо нэмэгдэж, илүү өрсөлдөөнтэй, сонирхолтой болсоор байна.

Энэ удаагийн тэмцээнд ГХС, MeTC-ийн хөтөлбөрийн ангийн оюутнуудын хамтарсан сагсан бөмбөгийн баг тэргүүн байр эзэлж алтан медаль, цом, ГХС, МХТС, MeTC-н 2+2 хөтөлбөрийн ангийн оюутнуудын хамтарсан баг олс таталтын тэмцээнд III байр, гар бөмбөгийн тэмцээнд шагналт байр тус тус эзэлсэн байна. Мөн сагсан бөмбөгийн шилдэг тоглогч MVP-р ШУТИС MeTC-н 2+2 хөтөлбөрийн I ангийн оюутан Г.Хүдэрбаатар шалгарч цом, өргөмжлөл хүртлээ. ШУТИС-н багийн хувьд 2014 оноос уламжлал болон зохиогдох болсон энэхүү тэмцээнд 2015 онд эрэгтэй сагсан бөмбөгөөр тэргүүн байр, 2016 онд эмэгтэй гар бөмбөгөөр тэргүүн байр, дээсний төрлөөр тэргүүн байр, 2018 онд сагсан бөмбөгөөр гутгаар байр эзэлж байсан амжилтаа ийнхүү бататган ахиулж чадлаа. Оюутнуудаа нэгэн зорилго дор нэгтгэж, тэмцээнд бэлдүүлсэн Б.Номиндалай багшдаа болон тэмцээнд идэвхтэй оролцсон ШУТИС-аар овоглосон оюутнууддаа сурлага, спортын өндөр амжилт хүсье.

## “ОРЧУУЛАХ ЭРДМЭЭС” ЦУВРАЛ УУЛЗАЛТ ЭХЭЛЛЭЭ

2021-11-17 11

2021-2022 оны хичээлийн жилд ГХС-ийн Ази судлалын салбарын солонгос хэлний багаас уламжлал болгон явуулах “Орчуулах эрдмээс” цуврал уулзалтаа Монгол улс дахь БНСУ-ын ЭСЯ-ны орчуулагч Б.Цацралыг урьж эхлүүлээ. Тэрбээр МУИС-ийн солонгос хэлний орчуулагч, орон судлаач мэргэжлээр төгссөн бөгөөд БНСУ-ын Сөүл хотын их сургуульд солилцооны оюутнаар суралцаж, Сөүлийн үндэсний их сургуульд магистрын зэрэг хамгаалсан мэргэжлийн орчуулагч юм.

Зочин маань ЭСЯ-нд 8 жил гаруй орчуулагчаар ажилласан туршлага дээрээ тулгуурлан мэргэжлийн болон синхрон орчуулга хийхэд юун дээр анхаарах, орчуулагч хүний хувьд баримтлах зарчим хийгээд мэргэжлийн ур чадвараа байнга хөгжүүлж байх талаар саналаа хуваалцлаа.

Хамгийн анх хийж байсан орчуулга, төрийн албаны болон салбар салбарын орчуулга хийж байсан туршлага, орчуулагчийн хайхрамжгүй байдал, эрдүү бардам байхаас улбаалан асуудал хэрхэн үүсч болох талаар тодорхой жишээ баримт дээр тайлбарласан нь мэргэжлийн орчуулагчийн ангийн оюутнуудад суралцагчаас “орчуулагч” болох бэлтгэл, хариуцлага, зорилгоо ухамсарласан бүтээлч байх зэрэг хувийн зохион байгуулалт, чадвар, сахилга бат ихээхэн шаарддаг зэрэг талаар уулзалтаа өрнүүлээ.

Хувь хүнийхээ хувьд мэргэжлийн орчуулагч болохын тулд дараах зарчмыг баримтлан ажиллахыг зөвлөлөө. Үүнд:

- Байнга суралцах хандлагатай бай
- Тасралтгүй бэлтгэлтэй бай
- Ямагт бэлэн бай
- Орчуулагчийн ёс зүй зарчимтай байх

Төгсгөлд нь сайн орчуулагч болоход бардам биш ямагт даруу байхыг хичээх, мэдэхгүйгээсээ ичихгүй байх, тухайн орны соёл уламжлал, ард түмний хэл сэтгэхүйг судлан орчуулахыг зөвлөн хэлэв. Энэхүү уулзалтад техник технологийн орчуулагчийн солонгос хэлний 4-р ангийн оюутнууд оролцсон ба уулзалтыг солонгос хэлний багш Б.Номиндалай санаачлан зохион байгууллаа.

